

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.01.06 - 01.10

Ти Ди Би Капитал ҮЦК нь Монголын хөрөнгийн биржтэй шууд холбогдсон арилжааны системийг ашиглан үнэт цаасны арилжаанд хамгийн түргэн шуурхай оролцох боломжийг олгож байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ болон Иран улсуудын хооронд зэвсэгт мөргөлдөөн болохгүй болсонтой холбоотой энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа.

Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс түүхэн дээд ханшид хүрсэн ба Apple компанийн БНХАУ-д хийсэн борлуулалт хүлээлтээс дээгүүр байсан болон Salesforce.com компанийн хувьцааны үнэ огцом өсөлт үзүүлснээс үүдэн технологийн салбар өсөлттэй байлаа. Ойрх Дорнодын хурцадмал байдал тогтворжсонтой холбоотой газрын тосны үнэ буурсан нь эрчим хүчний салбарын компаниудад сөргөөр нөлөөллөө.

АНУ-аас Иран улсын Хошууч Генерал Касем Солейманид хийсэн дронын цохилтоос үүдэн өнгөрөгч долоо хоногийн эхээр хувьцааны үнүүд бууралттай байсан ба Мягмар гарагт Иран улс Ирак улсад байрлах АНУ-ын цэргийн баазруу пуужингаар довтолсонтой холбоотой АНУ-ын хувьцаануудын үнэ дахин унасан ч энэхүү довтолгооны дүнд хүний амь эрсдээгүй байна. Лхагва гарагт АНУ хариу арга хэмжээ авахгүй бол Иран улс байдлыг хурцдуулахгүй хэмээн мэдэгдсэн ба АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп Иран улс довтолгоо хийхгүй болсон хэмээн мэдэгдсэнээс үүдэн хувьцааны ханш өсөн түүхэн дээд хэмжээнүүддээ хүрсэн байна.

Европ: Ойрх Дорнодын хурцадмал байдал намжсан болон АНУ болон БНХАУ-ын худалдааны хэлэлцээртэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа.

Энэ долоо хоногт Евро бүсийн үйлчилгээний салбарын өсөлт үйлдвэрлэлийн салбарын бууралтыг нөхсөнөөс үүдэн бизнесийн үйл ажиллагаа 12-р сарын хүлээлтээс илүү тогтворжсон байна. Мөн Евро бүсийн хэрэглээний үнийн индекс өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 1.3%-аар өссөн ба энэхүү өсөлт нь зул сарын баяртай холбоотойгоор хэрэглээ өссөнтэй холбоотой юм.

ХБНГУ-ын 11-р сарын экспортын хэмжээ шинжээчдийн хүлээлтээс их буюу 2.3%-аар буурсан байна. Энэхүү бууралт нь импортын хэмжээний бууралтаас их байснаас үүдэн ХБНГУ-ын гадаад худалдааны тэнцэл 10-р сарын дүн болох 21.2 тэрбум еврогоос бууран 18.2 тэрбум евро болсон байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд 2020 оны арилжааны эхний долоо хоногт өсөлттэй хаагдлаа.

Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ эдийн засгийг дэмжих зорилгоор худалдан авалтыг нэмэх шийдвэр гаргасантай холбоотой Японы төв банкаас 2020 оны эдийн засгийн өсөлтийн таамагаа нэмэх магадлалтай юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт дахин өсөлттэй байлаа.

БНХАУ-ын компаниудын хувьцааны ханш цагаан сарын баяр 1-р сарын 24-ний өдрөөс эхэлж байгаатай холбоотой өсөлт үзүүллээ. Түүхэн өгөгдөл дээр үндэслэн үзэхэд цагаан сарын баярын өдрүүд дөхөхөд БНХАУ-ын компаниудын хувьцааны ханш өсөлт үзүүлдэг байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,248.79	-1.35% ▼
Dow Jones	АНУ	28,823.77	0.66% ▲
S&P 500	АНУ	3,265.35	0.94% ▲
Nasdaq	АНУ	9,178.86	1.75% ▲
S&P/TSX	Канад	17,234.49	0.99% ▲
FTSE 100	Их Британи	7,587.85	-0.45% ▼
S&P/ASX 200	Австрали	6,929.00	2.90% ▲
Nikkei 225	Япон	23,850.57	0.82% ▲
Hang Seng	Хонг Конг	28,638.20	0.66% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	115.22
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	104.20
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.79
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.14
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.06
DBM' 2023	USD	7.250%	107.09
TDBM' 2020	USD	9.375%	101.85
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.49

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.677	-0.04 ▼
Libor 3M	1.838	-0.04 ▼
Libor 6M	1.872	-0.02 ▼
Libor 1YR	1.967	0.00 ▲
US 2YR Bond	1.570	0.06 ▲
US 3YR Bond	1.583	0.06 ▲
US 5YR Bond	1.632	0.06 ▲
US 10YR Bond	1.820	0.05 ▲

Валютын ханш	2020.01.10	Өөрчлөлт
USD	2,738.92	0.11% ▲
CNY	395.12	0.72% ▲
EUR	3,042.26	-0.30% ▼
RUB	44.66	1.55% ▲
KRW	2.36	0.85% ▲
JPY	25.00	-1.38% ▼
CAD	2,097.18	-0.63% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,552.20	2.76% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	18.06	1.65% ▲
Зэс	USD/lb.	278.70	-1.50% ▼
Нүүрс	USD/MT	69.47	0.32% ▲
WTI газрын тос	USD/bbl.	63.05	2.15% ▲
Brent газрын тос	USD/bbl.	68.60	0.65% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XI	5.2%
Бодлогын хүү	2019. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XI	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	11.49%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XI	4.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	16.88%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XI	10.58%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 308.3 сая төгрөгийн 2,281,238 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Инвекор ББСБ” /INV/ компанийн хувьцаа 17.40%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,584.0 төгрөгт хүрч хаагдсан бол “УБ-БҮК” /BUK/ компанийн хувьцаа 25.00%-аар буурч 300.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


01-р сарын 10-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,666.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,248.79 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.35%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	308.3
Зах зээлийн үнэлгээ	2,666,530.4

Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,248.79	-1.35% ▼
MSE I индекс	9,435.75	-0.68% ▼
MSE II индекс	7,780.47	-0.62% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	17,999	46,338,742
Мандал даатгал	763,359	38,529,794
Түмэн шувуут	232,876	35,811,878
Лэндмн ББСБ	820,635	33,872,468
АПУ	51,941	31,955,741

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Инвекор ББСБ	2,584.00	17.40% ▲
Дархан гурил тэжээл	5,600.00	14.78% ▲
Улсын их дэлгүүр	1,068.00	7.99% ▲
Ремикон	30.00	7.14% ▲
Мандал даатгал	52.06	3.95% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
УБ-БҮК	300.00	-25.00% ▼
Стандарт агрикалчер групп	77.00	-14.44% ▼
Монгол шуудан	605.00	-12.32% ▼
Бүтээлч үйлс	1,000.00	-9.09% ▼
Шивээ овоо	2,400.00	-6.25% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	90,216,211
Голомт Капитал	69,849,300
Ард капитал групп	65,116,996
Ти Ди Би Капитал	60,781,840
Бумбат-Алтай	52,576,181

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	616.79	656,377
Таван толгой	6,505.00	342,587
МИК Холдинг	15,000.00	310,640
Говь	277.14	216,200
Инвекор ББСБ	2,584.00	185,345

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ


- 2019 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 13 компани хэвээр үлдэж, 7 компани солигдлоо.
- “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ыг баталлаа
- Монголбанкнаас ФАТФ-ын 40 зөвлөмжийг орчуулжээ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- Говь ХК ногдол ашгийн үлдэгдэл дүнг хувьцаа эзэмшигчдийн дансанд 2019 оны 12 сарын 31-ний өдөр байршуулсан байна.
- “ЛэндМН ББСБ ХК” нь СЗХ-ны тусгай зөвшөөрлийн дагуу “Лэнд Хэтэвч” үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд зарим ойлголтын зөрүүтэй байдлыг тодруулахаар Монголбанкинд хандсан ба асуудлууд тодорхой болмогц тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүргүүлэхээр ажиллаж байна.
- “Ард Кредит ББСБ” ХК 2018 онд СЗХ-с тусгай зөвшөөрөл авсан ба үндэсний төлбөрийн системтэй холбоотой бүх асуудалд Монголбанк хяналт тавихаар болсны дагуу 2019 оны 9 сард Монголбанкинд цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтээ гаргасан болно.
- “Хорго Хайрхан” ХК-ийг “Монгол даатгал” ХХК-тай нэгтгэх шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэн байна.



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН



2019 онд нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 0.1 сая ширхэг үнэт цаасыг 9.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт МХБ дээр 143.2 тэрбум төгрөгийн (авсан дүнгээр) арилжаа хийгджээ.

2017 оны 11 сард ЗГҮЦ-ний анхдагч зах зээлийн арилжаа зогссонтой холбоотой 2018 онд ЗГҮЦ-ны арилжаа буурсан ч хувьцааны арилжаа өсөж 2018 онд нийт арилжаа 71.6%-аар буурсан. Харин 2019 онд ЗГҮЦ, компанийн бонд болон хувьцааны арилжаа бүгд буурсантай холбоотойгоор 2019 оны нийт арилжаа 2018 онтой харьцуулахад 41.2%-аар буурсан үзүүлэлттэй байлаа.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн төслийг УИХ баталлаа
- Монголбанкнаас тэтгэврийн зээлийн үлдэгдлийг мэдээлэв.
- ОУВС: тэтгэврийн зээл тэглэх шийдвэр "өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн зорилттой нийцэхгүй
- Агаарын тээврээр зорчигчдын тоо 2019 онд 14 хувиар өсжээ
- Дотоодын зах зээлд тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний борлуулалт 2019 онд 15 хувиар өсжээ
- Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн АНУ-ын Сангийн яамны Азийн асуудал эрхэлсэн дэд сайд Роберт Капротыг хүлээн авч уулзлаа




МАКРО ЭДИЙН ЗАСАГ

- Банкууд 2019 оны 12 дугаар сарын 31-ий өдрийн байдлаар 228.7 мянган зээлийн дансанд 757.9 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2018 оны эцэстэй харьцуулахад 167.5 тэрбум төгрөг буюу 18.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Нэг зээлдэгчид ногдох тэтгэврийн зээлийн хэмжээ дунджаар 3.3 сая төгрөг байна.
- Монгол Улсын гадаад худалдааны ашиг 2019 оны эхний 11 сард 1.5 тэрбум долларт хүрч гадаад валютын албан нөөц хуримтлагдахад эерэгээр нөлөөлж, 2019 оны 11-р сарын байдлаар гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларт хүрээд байна. Засгийн газар, Олон Улсын Валютын Сантай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 12 дугаар сард Азийн Хөгжлийн Банк 100 сая ам.доллар, 2020 оны 1 дүгээр сарын 3, 6-ны өдрүүдэд Дэлхийн банкнаас нийт 100 сая ам.доллар орж ирлээ.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Коксжих нүүрс болон төмрийн хүдрийн томоохон экспортлогч улс болох Австралийн Аж үйлдвэр, Инноваци, Шинжлэх ухааны яам 2020 оны төмрийн хүдрийн ханшийн таамгийг 3%-аар өсгөөд байгаа ч коксжих нүүрснийхийг 7%-аар бууруулахаар тогтлоо. Энэхүү тооцооллыг тус яам улирал бүрт гаргадаг түүхий эдийн үнэ ханшийн хамгийн сүүлд гаргасан (12 дугаар сарын) тайландаа тусгасан байна.

АВСТРАЛИЙН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ТААМГАГ 2019-2021
(САЯ ТОНН)



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.